

2023

ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН

Тухтай амьдралын эхлэл



АГУУЛГА



Компанийн танилцуулга



2022 оны бизнес төлөвлөгөө




Онцлох үйл явдлууд



Бизнесийн үйл ажиллагаа



Санхүүгийн үзүүлэлтүүд





Алсын хараа

Монгол өрхийн тав тухтай амьдралыг дэмжих орон сууцны санхүүжилтийн экосистемийг бий болгоно.



Үнэт зүйлс

Орон сууцны санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангах замаар ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлдэг.

Эрхэм зорилго



Ёс зүй

Тогтвортой
хөгжил

Мэргэшсэн
байдал

Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал:

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 23/08 дугаартай тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагаас live.mik.mn-р дамжуулан цахимаар зохион байгуулж, 94.03 хувийн ирцтэй хуралдууллаа. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Тус хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, хараат бус гишүүн Чулуундоржийн Хашчулуун удирдан явуулж, хуралд тооллогын комисс, хурал зохион байгуулах комисс болон компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан “Эрнст энд Янг Монголиа аудит” ХХК-ийн төлөөлөл оролцсон.

ТУЗ болон хороодын хурал:

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хурал нийт 4 удаа хуралдаж 10 шийдвэр гаргалаа. ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, аудитын хороо 5 удаа, Нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хороо 4 удаа, Эрсдэлийн удирдлагын хороо 2 удаа тус тус хуралдаж холбогдох дүгнэлтийг гаргасан.

Засаглалтай холбоотой тайлан мэдээ:


- Дараах тайлангуудын Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлж компанийн цахим хуудаст байршууллаа.
- 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулж хуралдуулсан талаарх тайлан;
- 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлан;
- 2022 оны жилийн эцсийн аудитын тайлан;
- “МИК Холдинг” ХК-ийн засаглалын үнэлгээний тайлан;
- Байгаль орчин, нийгэм засаглалын үйл ажиллагааны тайлан.

2023.02.03



- **560 тэрбум** төгрөгийн 30 хүртэлх жилийн хугацаатай ипотекийн зээлээр баталгаажсан бонд /ИЗББ/-ыг гаргав.

- **6,964 өрхийн** ипотекийн зээлийн хугацааг баталгаажууллаа.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2023.03.06



- Сингапур улсад болсон Олон улсын ипотекийн хоёрдогч зах зээлийн холбооны (ISMMA) ээлжит хуралд Монголын ипотекийн корпорацийн гүйцэтгэх захирал Б.Гантулга оролцлоо.

Тус хурлын гол үйл явдал нь орон сууцны санхүүжилтийн салбарт ижил үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хамтран ажиллах санамж бичиг байгуулж, ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг дэмжих чиглэлээр мэдлэг туршлагаа нэгтгэн олон улс, бүс нутгийн түвшинд илүү нягт хамтран ажиллахаар болсон.

САНАМЖ БИЧИГ



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2023.03.06



МОНГОЛЫН
ИПОТЕКИЙН
КОРПОРАЦИ ОССК
ХЯЗГААРЛАГДАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

- Филиппиний “Орон сууцны ипотекний санхүүжилтийн үндэсний корпорац” (NHMFC)-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулав.



- Малайзын “Чагамас Бэрхад” (Cagamas Berhad) буюу Орон сууцны санхүүжилтийн компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулав.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2023.04.20



- “Улаанбаатар – Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум 2023” арга хэмжээнд оролцлоо.
- “Орон сууцны салбарын санхүүжилтийн тогтолцоо, хөрөнгө оруулалт татах боломж” сэдэвт илтгэлийг “МИК ОССК” ХХК-ийн Бизнес, хөгжил хариуцсан дэд захирал Ц.Батбаяр хэлэлцүүлээ.

УБ - Олон улсын форум



Ulaanbaatar International
Investment & Partnership
Forum 2023

NEW RECOVERY - ULAANBAATAR



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2023.04.20

“МИК Холдинг”, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-тай гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд санхүүжилт, хөрөнгө оруулалт татах чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2023.04.28

- “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 23/08 дугаартай тогтоолын дагуу компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн өөрийн боловсруулсан программаар шууд дамжуулан цахимаар хуралдлаа.
- Тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс **94.03** хувийн ирцтэй оролцож, компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардлын төсвийг тус тус хэлэлцэж баталлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ





- Монголын ипотекийн корпораци ажилтнуудын эрүүл мэндийн иж бүрэн урьдчилан сэргийлэх ээлжит үзлэгийг өнгөрсөн хоёр долоо хоногийн хугацаанд “Дөрөвдүгээр эмнэлэг”-тэй хамтран амжилттай зохион байгууллаа.
- Гурван багц бүхий 32 төрлийн оношилгоо шинжилгээнд нийт 120 гаруй ажилтнаа хамруулсан.

МИК-ийн хамт олон мод тарих үндэсний өдөр хоёр байршилд мод тарилаа.



“Санхүүгийн Зохицуулах Хороо”-оос зохицуулалтын 16 байгууллагын дунд санаачилсан СХД-ийн 21-р хороон дахь “Инчеон Мөрөөдлийн төгөл”-д мод тарих уриалгад нэгдэн оролцож, хувь нэмрээ оруулсан бол AmCham Mongolia-с зохион байгуулсан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарих үйл ажиллагаанд мөн нэгдлээ.

2023.05.29



Хөрөнгө оруулагчдад зориулсан “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны санхүүжилтийн тогтолцоо” уулзалт



Хөрөнгө оруулагчдад зориулсан “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны санхүүжилтийн тогтолцоо” сэдэвт уулзалтыг НОСК, МИК хамтран зохион байгууллаа.



2023.06.08


ОУ-ын комплаенсийн менежментийн стандартыг нэвтрүүлсэн санхүүгийн салбарын анхдагч байгууллага боллоо



- Монголын ипотекийн корпораци нь олон улсын Комплаенсийн менежментийн ISO 37301:2021 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүллээ.


- Комплаенсийн менежментийн олон улсын стандартын тогтолцоог хэрэгжүүлсэн санхүүгийн салбарын хамгийн анхны байгууллага болж байна.

ИЗББ гаргасан дүн ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)



■ ИЗББ гаргасан дүн (тэрбум.төг) ● Зээлдэгчийн тоо

Буцаах нөхцөлтэй хэлцлийн эх үүсвэрийн бүтэц



Тайлант хугацаанд худалдан авсан буцаах нөхцөлтэй хэлцлийн эх үүсвэр



• Ам.Долларын бонд

- Бөртэ
Дүн: 250 сая ам.доллар
Гаргасан огноо: 2021.02.08
Дуусах огноо: 2024.02.08
Хүү: Жилийн 8.85%

• МИК Хаалттай бонд

Дүн: 12 сая ам.доллар
Гаргасан огноо: 2021.12.28
Дуусах огноо: 2024.12.28
Хүү: Жилийн 6.80%

- **МИК-ийн эх үүсвэр.** МИК-ийн өөрийн эх үүсвэр.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн үзүүлэлтүүд

	2022Q2	2023Q2
Ашигт ажиллагаа		
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	-4.0%	1.8%
Өөрчлөлтийн хувь (оны эхнээс)		
Нийт активын өөрчлөлт	-8.8%	8.8%
Зээлийн багцын өөрчлөлт	-2.3%	5.2%
Хөрөнгөнд эзлэх хувь		
Өөрийн хөрөнгө/Нийт хөрөнгө	-2.0%	0.8%
ИЗББ/Нийт хөрөнгө	79,8%	81.4%
МИК бонд/Нийт хөрөнгө	1.0%	0.2%
Бөртэ бонд/Нийт хөрөнгө	19.5%	15.9%

Гүйцэтгэл

	2022Q2	2023Q2
Орон сууцны зээлийн хөрөнгийн багц	3,233.0	4,082.9
Нийт хөрөнгө	3,853.6	4,954.7
ИЗББ	3,073.9	4,035.4
Гаргасан өрийн үнэт цаас	788.4	799.8
Өөрийн хөрөнгө	(77.5)	38.5

Ашигт ажиллагааны харьцаа

	2022Q2	2023Q2
Цэвэр хүүний маржин %	1.3	1.9

Хөрөнгийн бүтэц (нийт хөрөнгөд эзлэх %)

	2022Q2	2023Q2
Мөнгөн хөрөнгө	4.7	6.5
Орон сууцны зээлийн багц	83.9	82.4

БАЯРЛАЛАА

